

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 01дүгээр сарын мэдээ

2023.01.24

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: 2023 оны 01-р сарын 25 өдөр 01 сарын 11өдөр ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 5-р хуралдаан хуралдсан.

Үндсэн хуулийн 31 дэх өдөрт зориулсан АХА тэмцээнийг зохион байгуулсан. Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан албан байгууллага аж ахуй нэгж иргэдийн дунд “Далайд дусал нэмэр” хандивын уриалга гарган ажиллаж байна.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 25 албан бичиг ирсний 6 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Сумын засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/01 тоот захирамжаар цэргийн тоо бүртгэлийн ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 04-20 өдрүүдэд зохион байгуулагдсан.

Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбоотойгоор аймгийн аюулгүй нөөцөөс хуваарилсан 20 тонн өвсийг тээврийн зардлыг нэмж тооцон боодол тус бүрийг 8500 төгрөгөөр худалдсан.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 1 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгууллага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотариотоор баталгаажуулж , цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан, малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын төсвийг ИТХ-р хэлэлцүүлэн батлуулсан .

Санхүү төрийн сангийн хэлтсээс гүйлгээний программ шинчилэгдсэн холбогдуулан төсвийн байгууллагын нягтлан бодогч, дарга нарын хамт сургалтанд хамрагдсан .

Жилийн эцсийн өмч, санхүүгийн тайланг хугацаанд нь e-balance программд шивж байна .

Төсвийн газруудын 2022 оны 4-р улирлын тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, авлигын эсрэг хуулийн тухай болон ХАСХОМэдүүлгийг хэрхэн гаргах талаар төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт мэдээлэл аргачлал зөвлөмжийг өгч гарын авлага тараан ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Тухайн сард нийт үзлэг - 320, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг – 77 иргэн больницод хэвтэн эмчлүүлсэн – 54 үүнээс хүүхэд - 21, . Алсын дуудлага – 16 ирсэнийг дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар 34, лабораториор - 115 иргэнд шинжилгээ, 33 иргэнд өдрийн эмчилгээг цаг тухай бүрт хийсэн.

Рентгенд-53 үйлчлүүлэгчийн зургийг авсан. Сүрьеэтэй нэг иргэн шинээр илэрснийг АНЭ-ийн сүрьеэгийн тасагт шилжүүлсэн. Гэр бүлийн 4 хүүхдэд хавьтал илрүүлэх туберкулины сорил тавьсан. ЭХО-д – 42 иргэн харсан. Зүрхний цахилгаан бичлэг – 14 иргэнд хийхэд, Зүрхний шигдээс – 1-ийг илрүүлж АНЭ-рүү хүргэж өгсөн.

Томуу, томуу төст өвчин ихэссэнтэй холбоотой хүүхдүүдийн эцэг эхэд ханиад томуунаас сэргийлэх зөвлөмж 42 иргэнд тараасан. Шинээр: 10 литрийн зөөврийн боллан-3, боланы редуктар-3, Чийгшүүлэгчтэй редуктар-3 болланы тэргэнцэр-2 Хүчилтөрөгчийн маск-54-ийг авч үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна

Ерөнхий боловсролын сургууль: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын “АЛХАМ АЛХМААР” аян 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл үргэлжилж байна. Сүхбаатар аймгийн 4-р сургуулийн физикийн багш, математикийн багш нар ЕБСургуулийн 12 дугаар ангийн сурагчдад 7 хоногийн давтлага өгсөн.

2023 оны өсвөрийн шатарчдын ААШ тэмцээнээс 3 сурагч мөнгөн медаль хүртэж багийн дүнгээр 3-р байрт шалгарлаа. Мэдээлэл зүйн багш нар хамтран “Excel программд томъёо оруулах”, “Captive” сургалтыг зохион байгууллаа.

“ИРЭЭДҮЙН МАНЛАЙЛАГЧИД” 1-15 жилүүдэд ажиллаж буй багш нарын уулзалт болж өндөрлөлөө. Уг уулзалтын үеэр:

- “Хичээлийг бүтээлч заах”- ТНУ-ны багш
- “Сургалтын хөтөлбөр боловсруулх арга зүй”- Сургалтын менежер,
- “Байгууллагын соёлд-миний оролцоо”- МХУЗ багш
- “Сургалтын орчин”-Нийгийн ажилтан нар илтгэл тавилаа.

Хоол зүйч, сургуулийн эмч нар хамтран “Эрүүл зөв хооллолт” эрүүл мэндийн сургалтыг 01 сарын 23-ны өдөр зохион байгууллаа.

ЖЮУ ЖИЦҮ-гийн холбоодын бүсний ангилалгүй 2023 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд Г.Ихэрцэцэг Э.Долгоржав мөнгөн медаль, Г.Нарантунгалаг хүрэл медаль, ЖЮУ ЖИЦҮ -гийн бүсний ангилалтай улсын аварга шалгаруулах тэмцээний насанд хүрэгчдийн ангилалд Г. Насанжаргал алтан медаль, Өсвөрийн улсын аваргад Б.Мөнгөнчимэг алтан медаль, Д. Анударь А. Мишээл, Г. Нарантунгалаг нар тус тус мөнгөн медаль хүртлээ

Цэцэрлэг: “Тэгш таван ухаан төв” ТББ, APLUS.mn цахимаар модуль сургалтыг зохион байгуулж байгууллагын 12 багш, аргазүйч, нар хамрагдаж сургалтын “БАТЛАМЖ”-олгосон.

Сүхбаатар аймгийн БШУГ-аас зохион явуулсан Би залуу багш хөтөлбөрийн хүрээнд “Сайн сайхан зан чанарыг хэрхэн хөгжүүлэх вэ?” сэдэвт сургалтад багш Д.Амаа хамрагдан тус сургалтыг эцэг эхчүүдийг хамруулан байгууллага дээр зохион байгууллаа.

БШУ-ны сайдын 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/545 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын

багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, журам” сургалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн Мандарваа цэцэрлэгийн 10 жилийн ойн хүрээнд нийт цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагдсан гар бөмбөгийн тэмцээнд цэцэрлэгийн эмэгтэй баг амжилттай оролцсон.

Байгууллагын дэргэдэх залуучуудын баг хамт олон энэ сарын 13 ны өдөр “ЗАЛУУС БИД- ХАЙР ТҮГЭЭЕ” үйл ажиллагааг зохион байгуулж энэ үеэр байгууллагын багш ажилчдыг хамруулан үдийн цайнд оруулан хөгжөөнт тэмцээн зохион байгуулж амжилттай оролцсон багш ажилчдыг шагнаж урамшууллаа.

Жил бүр БШУЯ-аас уламжлал болон явагддаг илтгэлийн нэгдүгээр шатыг байгууллага дээр явуулан багш нар “БОЛОВСРОЛ ДОХ ЁС ЗҮЙН АСУУДАЛ ШИЙДЭЛ” сэдвийн хүрээнд нийт багш арга зүйч нар илтгэл тавьснаас арга зүйч Д.Хишигдүүрэнгийн илтгэл нэгдүгээр шатанд шалгарч 2-р шат Боловсрол соёл урлагийн газарт илгээгдсэн болно.

“Онлайн кабинет” төсөл хөтөлбөрийн хүрээнд аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 55” –ийн ухаалаг дэлгэцийг хүлээн авлаа. Цэцэрлэг ухаалаг дэлгэцтэй болсоноор бага насны хүүхдүүд болон багш ажилчид орон зайнаас үл хамааран цахимаар суралцах нөцөл боломж бүрэн хангагдлаа.

БШУГ-аас “СӨБ-ийн хөтөлбөрт эрүүл мэндийн боловсролыг тусган хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалт 01 сарын 18,19 –ны өдрүүдэд зохион байгуулагдаж Эрхлэгч , Арга зүйчийн хамт хамрагдлаа.

Цаг агаарын байдал эрс хүйтэрсэнтэй холбогдуулан галч нарын ажлын цаг барилт ажлын чанарыг сайжруулах зорилгоор хариуцлагатай жижүүр томилон багш нар тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын багш ажилчдын ар гэрт анхаарал хандуулан цэцэрлэгийн захиргаанаас нүүрсний тусламж дэмжлэг үзүүллээ.

Соёл: 1-р сард соёлын төвийн номын сан ажлын 8 цагаар ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа. Байнгын уншигч 17, ирэгсэд 64 хүнд 98 ном гэрээр олгож 5 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 3 татгалзал бүртгэлээ.

Судар эгшиглэн төслийн шилдэг уншигчыг ангилал тус бүрээс хоёр хоёр хүн шалгаруулж, шагнаж урамшуулсан.

Номын сангийн автоматжуулалтын Lib4U программд фондын номыг оруулах уншигчийг бүртгэх ажлыг хийж байна.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Хөдөө аж ахуй: Улс, аймгийн аварга өрх шалгаруулах журмын дагуу улсын аваргад 2 өрх, аймгийн аварга өрхөд 3 өрх, мөн алтан төлийн эзэн шалгаруулах журмын дагуу алтан хурга, ишиг, тугалд тус бүр нэг, нэг малчны материалыг бүрдүүлэн сумын Засаг даргын зөвлөл хэлэлцэн дэмжиж, аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн нөөцөөс 20 тн өвс сумын нөөцөөс 35 тн өвс нийт 55 тн өвс малчдад олгосон.

7 хоног бүрийн 3 дахь өдөр хорогдлын мэдээг аймгийн ХХААГ-ын мэргэжилтэнд хүргүүлж байна.

Сумын хэмжээнд нийт 2063 толгой мал хорогдсон. Үүнд: адуу-111, үхэр-184, хонь-754, ямаа-1014.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн